

Монгол шүлгийн туурвил зүйн зарим асуудал

Г.Галбаяр⁶⁴

Монгол уран зохиол, тэр дундаа яруу найраг олон зуун жилийн түүхтэй ч өдгөө хүртэл нэгдсэн ерөнхий тогтолцоо, туурвил зүйн онолын томъёололтой байсан үгүй нь эргэлзээтэй явж иржээ.

Монголын ард түмэн ардын аман зохиолын баялаг өв уламжлалтай бөгөөд түүний дотроос баатарлаг тууль, домог үлгэр, оньсого таавар, зүйр цэцэн үг зэрэг төрөл зүйлд уран үгийн зохиолын талаар санаа бодлоо илтгэсэн зүйлүүд цөөнгүй байгаа нь нэгэн зүйл ардын туурвил зүйн үндэс, утгыг зохиох онолын зарим бүтвэр гэж үзэх үндэстэй юм. Мөн монголын хуучин цагийн бичиг зохиолд зохиол, үг зохиол, утга уянга, яруу найруулга, тууль, тууж, туурь, шүлэг, дуулал, домог, үлгэр, хууль, дууль, ерөөл, магтаал, холбоо, хоршоо гэх зэрэг уран зохиолын олон төрөл зүйлийн болон онолын баялаг нэр томъёо тохиолддог нь энэ бүхний талаар уран зохиолын онолын мэдлэг ялгамжаа төсөөлөлтэй байсны гэрч баримт болно. Монгол уран зохиолд эрт үеэс “Гэсэр”, “Жангар”, “Монголын Нууц Товчоон”, “Эр хоёр загалын тууж”, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шасдир”, “Аргусан хорчийн домог” гээд хүн төрөлхтний оюуны сан дахь сонгодог уран зохиолын дунд зүй ёсоор тооцогдох бүтээлүүд цөөнгүй бичигдсэн бөгөөд “Энэ мэт сонин сайхан өвөрмөц уран бүтээлийг утга зохиолын онолын үзэл төсөөллийн тогтолцоотой мэдлэггүйгээр зохиочихсон гэхэд эргэлзээтэйн дээр туурвин зохиох оюуны хөдөлмөрийн энэ мэт туршилага нь утга зохиолын онолын бодол сэтгэлгээг хөгжүүлэх үндэс, түлхэц нөхцөл болоогүй гэж итгэхийн аргагүй ..., монголчууд нийгмийн аж төрөл хөгжлийн зохисгүй нөхцөлийн улмаас утга зохиолын талаархи онолын тэр мэт мэдлэг төсөөллөө гагцхүү бичиг сударт тодорхой томъёолон илтгээж чадаагүй, эсвэл чадсан боловч тэр нь уламжилж ирээгүй үрэгдсэн, эсвэл туйлын өсөрмөц илэрхийлснийг нь хойч үеийн бид нар нарийвчлан олж судлан гаргаж хараахан чадаагүй байна”⁶⁵ гэсэн нь хойч үеийн бидний нарийн судалгаа шинжилгээний үүдийг нээх үг гэж үзэж байна.

Монгол уран зохиолын судлалын түүхээс үзэхэд уран зохиолын онолын сэтгэлгээний тухай тогтолцоотой дуугарч эхэлсэн нь XVII зууны үетэй холбогдож байна. Энэ үеэс эртний Энэтхэгийн утга зохиолын онолын үзэл баримтлалыг, тэр дундаа ЭТ VII зууны орчмын онолч Дандины “Kavayadarsha” буюу “Үг чимгийн шастир зохист аялгууны толь хэмээх оршивой” бүтээлийн тухай дэлгэрүүлэн авч үзсээр иржээ. Энэ үеэс хойшх монголчуудын утга зохиолын онолын сэтгэлгээний тухай академич Ц. Дамдинсүрэн “Алаша-гийн Дандар Лхарамба арван наймдугаар зууны сүүлийн хагаст Энэтхэгийн Дандины “Яруу найргийн толийг” судалж түүнийг жишээ болгон уран шүлгийн онолыг бичсэн байна. Түүнээс хойш иймэрхүү шүлгийн онолыг төвд хэлээр зохиосон хүн монголд нэлээд бий. Цахар гэвш Лувсанчүлтэм, Зая бандид Лувсанпэрэнлэй,

⁶⁴ МУИС, ШУС, ХУС

⁶⁵ Гаадамба Ш. Утга зохиолын онолын үндэс. Уб., 1989. 22 дугаар тал

бичээч цорж Агваанцэрэн нар тус тус уран зохиолын шүлгийн онолыг бичжээ. Харин Хайдав хамбын зохиосон ший цамын шастирт үргэлжилсэн зохиол, дуу хөгжим бүжгийн онолыг хамарч бичсэн байна”⁶⁶ хэмээн бичсэн байдаг боловч сүүлийн үеийн судлаачдын⁶⁷ үзэж байгаа үзэл баримтлалаар XIX зууны төгсгөл, XX зууны эхэн үеийн Агваантүвдэнгийн “Зохист аялгуун толь”-ийн тогтоосон тэмдэглэл дурдлыг тодруулагч”, Жамъянгаравын “Зохист аялгууны үндэс хийгээд тайлбарын нийт утгыг сайтар агуулсан Эсэруагийн эгшиг дуун” гэсэн зохиолууд бие даасан монгол уран зохиолын онолын бүтээлүүд болж чадсан байна. Үүнээс хойш XX зуунд С. Буяннэмэх⁶⁸, Ш. Гаадамба⁶⁹ тэргүүтэй хэд хэдэн онолч монгол уран зохиолын бие даасан онолын бүтээл туурвисан билээ.

Дээрх түүхээс үзэхэд XIX зуунаас өмнө монголчууд бие даасан туурвил зүйн онолтой байсан эсэх нь маргаантай болох нь тодорхой. Бидний судалгаа шинжилгээний баримтаас үзэхэд монголчууд “бичигдээгүй туурвил зүйтэй байсан” /Б. Я. Владимирцов/ өвөрмөц ард түмэн гэдгийг ухварлан ойлгож, тэрхүү бичигдээгүйгээр зохиол бүтээл дундаа уусан шингэсэн онолын тогтолцоот үзлийг нээх нь чухал юм. Өөрөөр хэлбэл монголчуудын бичсээр ирсэн утга соёлын арвин баялаг бүтээл туурвилыг шинжлэх ухааны дэвшилтэд хийгээд тохиромжтой олон арга барилын үндэслэлээр задлан шинжилж, ажиглан туршиж, ухварлан үнэн бодитой дүгнэх нь зүйтэй юм. Ингэж судлаж гэмээ нь нэгд, монголчууд хүн төрөлхтний урлаг, уран зохиолоон туурвиж ирсэн нийтлэг сэтгэлгээ, хэв загвар буюу онолын ойлголтыг хэрхэн ойлгож, өөрсдийн бүтээл туурвилд ямар онцлогтойгоор гаргаж тавьсаныг, хоёрт, монголчуудын аж ахуй, соёл иргэншил, туулж ирсэн түүхэн зүй тогтлоос хамааралтай бие даасан онолын сэтгэлгээний загвар нь юунд үндэслэсэн, ямар онцлогтой байсан нь тодорхой харагдана. Энэ асуудлыг тодруулна гэдэг ганц нэг хүний, хоёр нэг илтгэл өгүүллийн түвшинд шийдэгдэх хялбар ажил биш ч гэсэн энэ удаад тодорхой хэмжээний асуудлыг хөндсөн ажиглалт хийснээ товчхон өгүүлье.

Монголчуудын туурвиж ирсэн бүтээл туурвилын нэн эрт үеээс улбаатай бөөгийн дудлагад /харын/:

Галзуу чонон хөлөгтөнгүүд
Гал могойн таиууртангууд
Хүний махан хүнстэнгүүд
Хүрэл чулуун зүрхтэнгүүд ...
Сүр их сүртэнгүүд
Бар их бараатангууд
Баатар хүдэр хүчтэнгүүд
Барчид гэмээс зайлуул ...
Гарахад ганзгыг нэм
Ороход олзыг нэм
Явсныг янзал

⁶⁶ Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. Уб. 1957. 16-17 дугаар тал

⁶⁷ Хүрэлбаатар Л. Эсэруагийн эгшиг дуун. Уб., 1999, Утга зохиол судлалын унших бичиг. Уб., 1995. 85-95 дугаар тал, Ёндон Д. Төвд, Монголын уран зохиолын харилцааны асуудалд. Уб., 1980

⁶⁸ Буяннэмэх С. Уран зохиолын үүд. Уб., 1936

⁶⁹ Гаадамба М. Утга зохиолын онолын товч. Уб., 1958, Утга зохиолын онолын үндэс. Уб., 1989

Очсонийг олзлуул ...⁷⁰ хэмээн өгүүлсэнээс үзвэл толгой, сүүл холбосон буюу нэг шад нөгөө шадтайгаа хэлний зүйн тогтолцооны үндэслэлээр уялдан холбогдсон болох нь тодорхой байна. Үг үсгийн зохилдолго, бие биенээ дуудагдах хөг эгшгээр найрч зохицох зүй тогтол нь айзам хэмнэл, үе өргөлт тэгш шадуудыг үүсгэжээ. Өөрөөр хэлбэл монгол хэлний эгшиг, гийгүүлэгчүүдийн дэс дараа, эрэмбэ, бие биеэнтэйгээ хамаарах хамаарлын асуудал энд хөндөгдсөн байгаа нь тодорхой байна.

Монгол ардын аман зохиолын хамгийн шилдэг загвар эталон болсон зүйр цэцэн үгэнд:

Ажил хийж хүн болдог

Ар давж хүлэг болдог

Алды нь аваад дэлэм дээр нь

Атгы нь аваад чимх дээр нь

Аяган хариу өдөртөө

Агтан хариу жилдээ

Бурууд нүд хурц

Болсонд шүд хурц

Ган болоход булгийн сайн мэдэгдэх

Гай болоход нөхрийн сайн танигдах

Ганц дээлт барилдаач

*Ганц морьт уралдаач ...*⁷¹ гэсэн жишээнээс харахад дээрхийн адил шад

бүрийн толгой, сүүлийг маш нарийн чинад холбосон байгаагийн гадна шад бүрийн дунд холболт хийжээ. Энэхүү холболтууд нь авиа, үе, үгийн бүтцэд үндэслэгдсэн байхын хэрэгцээ монгол хэлний холбоо, хоршоо, эсрэг утга, ижил утгатай ...үгүүдээр хийгдсэн байдаг онцлогтой байна. Дээр нь шад бүрийн үеийн тоог тэкцүүлэхэд онцгой анхаарал хандуулсан байгаа нь монголчууд зохиол бүтээлээ туурвихдаа хэм тэгшийн зарчмыг нарийн баримталдаг болох нь тодорч байна. Мөн шүлэг нэг буюу хэд хэдэн бадгаас бүтэх бөгөөд ихэвчлэн нэг төрлийн бадагтай байдаг нь тухайн шүлэгтээ холбоц ба ерөнхий аялгаар дахин давтагдах шинж чанартай байгааг харуулж буй хэрэг юм. Бадгийн ачаар шүлэг зохиол эмх цэгцтэй, хэмжээ хэмнэл нь тохирох ба бадгийн бүтэц тухайн улс үндэстний зан заншил, соёл иргэншил, урлаг болоод ертөнцийг үзэх үзлээс нь ихээхэн хамаардаг. Тийм учраас монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж юу болох нь монгол шүлэг судлалд нэлээд чухал асуудал юм.

Монгол шүлгийн бадаглал зүйг судласан эрдэмтэд янз бүрээр үзэж иржээ. Энэ бол монгол шүлгийг дотооддоо нарийн зүй тогтол, ээдрээ төвөгтэй нарийн нягт ур хийцтэй өвөрмөц уламжлал шинэчлэлийн холбоонд хөгжиж ирснийг харуулж байна. Нөгөө талаас ямар ямар шалгуур үзүүлэлтээр бадгийг судлахаас олон зүйлийн үнэний асуудал шалтгаална. Гэхдээ ямартаа ч бадаг оршин байх гүн ухааны тулгуур үндэслэлтэй байх нь нэн чухал үзүүлэлт юм.

Бидний ажиглалтаар монгол шүлгийн бадаглалын хамгийн бага нэгж нь хоёр шад буюу хос уянга юм. Хос уянга нь хоёр шадаас бүрдэж нэг цогц утга илэрхийлдэг зүйл. Монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж юм. Үүний учир нь монголчууд ертөнцийг сайн-муу, сайхан-муухай, эр-эм, өдөр-шөнө гэхчлэн хоёр туйлын эсрэгцлийн үр дүнд арга, билгийн шүтэлцээнд оршдог гэсэн суурь үзэл дээрээ үндэслээд хоёр шад шүлгэнд хорвоо

⁷⁰ Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Уб., 1978. 106 дугаар тал

⁷¹ Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Уб., 1978.13-14 дүгээр тал

тэр чигээрээ багтана гэж үздэгтэй холбоотой. Тийм ч учраас монгол үндэстний хөгжмийн үндсэн зэмсэг болох морин хуур хоёр утастай байдаг. Үнэхээр энэ хоёр утас, хоёр шад шүлгэнд ертөнцийн бүх өнгө, хослол, дүр зургийг гаргаж болдог. Эрт цагаас дорно хийгээд өрнө дахиныхан мал амьтан дөрвөн хөлийн алхаа гишгээгээр явдагт суурилж шүлгийн үндсэн нэгж болох бадгаа мал амьтаны оршин байх аргын нэгэн адил дөрвөн шадаас бүрддэг гэж үзэж байсан бол монголчууд мал амьтаныг биш хүнийг, хүний хөгжлийг илүүд үзэж, хүний хоёр хөл дээрээ явах нь хамгийн төгс зохицол гэж ойлгоод шүлгийн бадгийн үндсэн нэгжээ хоёр мөрөөр буюу хос уянгаар томьёолсон байна гэж хэлж болно.

Хос уянгын тодорхой жишээ нь бидний онцлон авч үзэж байгаа монгол ардын зүйр үг, цэцэн үг билээ. Эртний мэргэн үгэн дотор:

“Зүйргүй үг байдаггүй”

Зүйдэлгүй дээл байдаггүй” гэж өгүүлсэн үг байгаа нь уг чанартаа ямар ч зүйлийн мөн чанар, утга агуулгыг илэрхийлэхэд зүйрлэн хэлэх нь хамгийн шилдэг арга, ямар ч дээлийг /дээл нь монгол гадуур хувцасны хамгийн шилдэг загвар эталон юм/ зүйж, эсгэж оёохоос өөр аргагүйг харуулсан гүн ухааны хос уянга юм.

XIII зууны үеийн Монголын уран зохиолын дурсгал болох “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир” зохиолд:

“Үгтэй бол

Өч чи

Хошоотой бол

Холбо чи” гэж өгүүлсэн байгаа нь “Хэлэх үг байвал хэл, холбох хошоо байвал холбо” гэсэн утга тээсэн ч, “үгийг өчдөг, хошоог холбодог” юм гэсэн санаа давхар харагдана. Түүгээр ч барахгүй бидний яриад байгаа хоёр мөр шүлэг буюу хос уянгыг “хошоо” гэж эртний монголчууд нэрлэдэг байсан нь ойлгогдохын хамт үг гэдэг бие даасан ойлголтын зэрэгцээ хошоо гэдэг мөн бие даасан зүйл байсан нь батлагдаж байна. Дээрх жишээ баримтаас үзвэл үг холбож хошоо болгодог журмаар монгол шүлэг бичигддэг байжээ. Үүнийг бүр лавшруулан үзвэл монгол зүйр цэцэн үгийн нэн эртний төлөөлөл гэж хэлж болох:

“Сүн далайг шалбааг байхад

Сүмбэр уулыг дов байхад

Захын модыг зулзага байхад

Загал бугыг янзага байхад ...” гэх зэрэг хэвшмэл зүйрлэн цэцэлсэн хэллэгүүдээс олон зүйлийн ээдрээ тайлагдана гэж үзэж байна. Учир нь дээрх цэцэн хэвшмэл хэллэг өөртөө бүх зүйлийн эх язгуурын утгыг тээсний дээр зүйр цэцэн хэвшмэл хэллэгийн төлөөллийн хувьдаа эрт үеэс үүсэн олон мянган жилийг туулан боловсорч өдгөө монгол зүйр цэцэн хэллэгийн шилдэг загвар болсон аж. Үүний баталгаа нь өдгөө бидэнд уламжилж ирсэн олон туулийн эхэнд дээрх хэвшмэл хэллэг хэлэгддэг болсон явдал юм.

Дээр өгүүлсэн зүйлийг нэгтгэн үзвэл хос уянга буюу хошоо нь монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж ажээ. Иймд хос уянга буюу хошоо нь монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж мөний хувьдаа монгол үндэстний шүлгийн уугуул бие даасан төрөл зүйл болно гэсэн дүгнэлт урган гарч ирж байгаа төдийгүй монголчуудын аман болоод бичгийн яруу найргийн анхдагч нэгж болж байна. Монгол шүлгийн дотоод зүй тогтлоос ийм дүгнэлт урган гарч байгаа тул хос уянга буюу хошоо нь Японы хайку, Солонгосын шижү, Грекийн дистих, өрнөдийн сонет ... зэрэгтэй нэгэн адил бие даасан төрөл зүйл юм. Үүгээрч зогсохгүй хос уянга буюу хошоо нь хайку, шижү, дистих, сонет, ... зэрэгтэй

нэгэн адил бүтэц байгуулалтаараа чанд зохион байгуулалтыг эрхэмлэдэг ч утга агуулгыг илэрхийлэхийн тал дээрээ чөлөөт үзлийг эрхэмлэсэн байгаагийн зэрэгцээ зөвхөн монгол төдийгүй ерөөс шүлгийн бүтцийн ерөнхий бүх шинж төрх, арга билгийн зохилдолгоог агуулсанаараа ихээхэн давуу талтай нь харагдаж байна.

Мөн монгол уран зохиолын өвөрмөц нэгэн зүйл болох ертөнцийн гуравт:

Өсөхөд шүд цагаан

Өтлөхөд үс цагаан

Үхэхэд яс цагаан /цагаан/

Жавартай тэнгэрийн хаяа улаан

Жаргалтай хатны хацар улаан

Жалганд ургасан сухай улаан /улаан/ ...⁷² хэмээн өгүүлсэн байгаагаас харахад дээр өгүүлсэн онцлогууд давхцан илэрсэн байна. Гол онцлог нь гурван шадаар бадагласан байгаа явдал юм. Энэ нь монгол шүлэгт гурван мөрөөр бадаглах ёс нэн эртнээс үүсэлтэй буюу гүн ухааных нь суурь үзэл нь энэ орчлон хорвоог монголчууд өнгөрсөн-одоо-ирээдүй гэсэн гурван цагийн орчилд оршин байдаг, аливаа амьд амьтан энэ-одоо-хойт насны дунд амьдардаг, энэ ертөнц өөрөө тэнгэр-газар-лус гэсэн гурван зүйлийн уялдаа холбоонд оршидог гэсэн үзэл болно. Энэ бүхэн нь угтаа бол монгол шүлэгт гурван шадаар бадаглах ёс байсныг улмаар цаашид зургаа, ес ...гэх мэтээр бадаг үүсгэх үндэслэлтэйг харуулж байна.

Тэгвэл одоогоор мэдэгдэж байгаа хамгийн анхны монгол бичгийн уран зохиолын дурсгал болох “Хүннүгийн гунигт дуу” /ЭТӨ III зуунд хамааралтай/ -нд:

ᠰayan ayula-ban aldayad

Jiryuyan qosiyu mal mini ᠥskū-ben bolil-a

Yayan ayula-ban aldaya

Abayai keiken-ūd mini engeske ūgei bolul-a хэмээх юмуу аль эсвэл “Ахын дуу”-нд:

Aqan mini yabučiqaqad ergejū iregsen ūgei

Salan qayačaqu amarqan

Akin bey-e bey-e-tei-ben ayuljaqu kečegū

Aduyu nočuldun-a, kūmūn nočulduqu ūgei ... гэх шүлэглэсэн бол монгол бичгийн уран зохиолын гол дурсгал болох “Монголын Нууц Товчоон”-д:

Hodutai tenggeri

Horcijū būle`e

Olon ulus bulqa būle`e

Oron-dur-ıyan ūlū oron

Oljalaldun būle`e

Kōrisūtei etūgen

Kōrbejū būle`e

Gūr ulus bulqa būle`e

Kōñjile-de`en ūlū gebten

Gōrūleldūn būle`e⁷³ гэж өгүүлсэн байна. Тэгвэл Лувсанданзаны “Алтан

товчид:

Altan bey-e-ben amusu kemebesū

Aqu tōrū minu aldayıjai

⁷² Монгол ардын аман зохиолын дээж бичиг. УБ., 1978. 146 дугаар тал

⁷³ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols.*, Bloomington. 1972 p-150

Būitūn bey-e-ben amusu kemebesū

Būrin ulus minu samturayujai

Altan bey-e minu aljiyabasu aljiyatuyai

Aqu tōrū minu būū aldaratuyai

Būitūn bey-e minu jobobasu jobatuyai

*Būrin ulus minu būū samturayujai*⁷⁴

хэмээн бичсэн байгаагаас нийтэд нь дүгнэж үзвэл өмнө тэмдэглэсэн нийтлэг онцлогууд ажиглагдаж байгаа төдийгүй монголчууд уран зохиолд үзэл санаа, утга агуулга нэн чухлын зэрэгцээ хамгийн гол нь уран сайхан болохыг олон талын уялдаа холбоонд нь тогтолцоотой ойлгож байсан байна. Тийм ч учраас хожим С. Буяннэмэх “Гадаад хэлбэр нь уншиж үзэхэд тааламжтай, сонсоход чимэгтэй, дотоод утга чанар нь үзэх тусам, бодох тусам барагдашгүй гүн нарийн”⁷⁵ байна гэж тодруулжээ.

Монгол аман зохиолын хийгээд бичгийн уран зохиолоос үзэхэд уран зохиол бол хүнийг нээхүйн урлаг гэдгийг монголчууд эртнээс гүн нарийн ухаарч байсан болох нь тодорч байна. Монголчуудын уран зохиолын өөр нэг онцлог нь үнэнийг уран сайханд уусган бичдэг байсан нь орчин үеийн уран зохиолын онолын тулгуур ойлголт болох “үнэн, уран сайхан, философи гурвын нэгдэл”⁷⁶ байдаг ухагдхууныг ухаарч байжээ. Тийм ч учраас монгол уран зохиолын бичигдээгүй онолын энэ ойлголтоос үүдэн хожим С. Буяннэмэх “Үнэн хэргийн түүхт тэмдэглэлийг даруй уран яруу өгүүлэлттэй болгож үлгэрчилэн бичиж уншихад зохистой уран яруу найруулгатай”⁷⁷ болох нь чухал гээд “онц сонирхлын зүйлээр ховор дутмаг бол ер нэг энгийн түүх мэт болно”⁷⁸ гэжээ. Энэ мэтээр уран зохиолын онолын ерөнхий ойлголт болох уран сайхны тухай, ёс суртахууны тухай, уламжлал шинэчлэлийн асуудлуудыг нэн нарийн зүй тогтолтой ойлгож ирсний зэрэгцээ төрөл зүйл, уран сайхны дүрийн төлөвшил, яруу найргийн бүтээлийн бадаглал зүйн хэм хэмжээ, айзам хэмнэл зэрэг олон асуудлыг онолын тулхтай мэдлэгийн үүднээс ухаарч, зохиол бүтээлээ нарийн бие даасан туурвил зүйн үүднээс туурвиж ирсэн ард түмэн байна.

Монголчуудын эрхэлж ирсэн нүүдлийн аж ахуй түүнээс үүдсэн нүүдлийн эрх чөлөөт, хэний ч хараат бус соёл иргэншлийг бий болгосон. Энэ нь угтаа монголчууд эрх чөлөө, чөлөөт сэтгэлгээг нэн тэргүүнээ эрхэмлэн дээдэлж ирснийг харуулж байгаа юм. Тиймд тэдний бүтээсэн уран зохиол нь ямар нэг дүрэм журам, хэм хэмжээнд огтхон ч баригдахгүй чөлөөтэй бичигдсэн гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл хаослаг, шугаман бус шинж чанартай ажээ. Тодруулбал монголын уран зохиолд сэтгэл санаа, сэрэл мэдрэмж, бэлгэдэлт шинж давамгайлсан яруу сайхны дээд гайхамшигт зураглал, утга агуулга тэргүүтнийг урлан бүтээсэн байгаа нь дээрх жишээ баримт, ажиглалт дүгнэлтээс тодорхой харагдаж байна. Монгол уран зохиол ийм онцлогтой учир тогтсон нэг томъёолол, өөрөөр хэлбэл ийм зүйлийг ингэж бичнэ, тийм зүйлийг тэгж бичнэ гэсэн туурвил зүйн тогтсон онолгүй явж ирсэн мэт бидэнд сэтгэгдэл төрүүлсээр иржээ. Гэвч энэ цаанаа нарийн учир чансантай бололтой. Үүний учрыг тайлбарлахын тулд өөр нэг зүйлийг авч үзье.

⁷⁴ Erten-ü qad-un ündüsülegsen tōrū yosun-u jokiyal-i tobčilan quriyaγsan altan tobči kemekū orusibai. Orusil bičigsen Ša. Bira., Ulaγanbayatur 1990 . p-109

⁷⁵ Хэл зохиол судлал. Х боть. Уб., 1975. 224 дугаар тал

⁷⁶ Галбаяр Г. Уран зохиол шинжлэлийн лекц. Уб., 2002. 156 дугаар тал

⁷⁷ Хэл зохиол судлал. Х боть. Уб., 1975. 226 дугаар тал

⁷⁸ Хэл зохиол судлал. Х боть. Уб., 1975. 226 дугаар тал

1827 онд Английн ботаникч Браун Роберт усан доторх жижиг тоосонцрууд эмх замраагүй хөдөлж байгааг анх ажиглан судалгааны эргэлтэнд оруулсныг хожим физикчид хий ба шингэн доторх бичил хатуу биет нь хий шингэний молекулуудтай мөргөлдөн эмх замбараагүй чиглэлд хөдөлдөг болохыг тогтоосон төдийгүй тэрхүү эмх замбараагүй хөдөлж байгаа молекулууд эцсийн дүндээ ус хэмээх тодорхой шинж чанартай, тодорхой чиглэлд эмх цэгцтэй хөдөлдөг бодисыг бий болгож байгааг нээн тодруулсан байдаг. Өөрөөр хэлбэл орчны зуурамтгай шинж чанар, халуун хүйтний нөлөө зэрэг үйлчлэлээр тэрхүү эмх замбараагүй хөдөлгөөнийг далд байдлаар захирч, үр дүнд нь ус хэмээх эмхлэгдсэн тогтолцоот бодисыг үүсгэдэг жам ёсны физикийн далд хууль байгааг харуулж байна. Энэ бол эмх замбараагүй эгэл биесийн хөдөлгөөн агуулж байгаа зүйлээ эмх цэгцтэй үр дүнд хүргэдэг болохыг зааж байгаа хэрэг юм.

Энэ үзэгдэлд өнөөдрийн байдлаар бараг бүх шинжлэх ухаан анхаарлаа хандуулж байна. Энэ шинжлэх ухаануудын нийлэмжийг синергетикийн шинжлэх ухаан буюу шугаман бус шинжлэх ухаан гэж нэрлэж байна. Өөрөөр хэлбэл ээдрээ төвөгтэй зүйлсийн учрыг олоход чиглэгдсэн шинжлэх ухаан гэсэн үг.

“Брауны хөдөлгөөн” гэж нэрлэгдсэн энэ үзэгдэл хийгээд ертөнцийн мөн чанарын гол зүйл нь аливаа зүйл бүгд өөрийнхөө оршин байхын тулд л хөдөлгөөнд оролцож байдгаас бус ямар нэг нэгдмэл зорилтыг өмнөө тавьдаггүй нь харагддаг байна. Гэтэл яг энэхүү зөвхөн өөрийнхөө төлөөх эмх замбараагүй хөдөлгөөн нь амьд байгалийн эмх цэгц, тэнцвэрт харилцааг бий болгох шалтгаан нь болдог байна. Энэ үзэгдлийн үнэнийг олон зүйлээс сүүлийн үед харж болохыг дээр өгүүлсэн синергетикийн шинжлэх ухаан нээн тодруулж үнэ цэнийг нь нэмэгдүүлж байна гэж хэлж болно. Тухайлбал нийгэм дээрх хамгийн өргөн дэлгэр, хамгийн ойрын салбар болох эдийн засгийн хувьд л гэхэд сүүлийн үед хамгийн их яригдаж түүнийхээ хэмжээгээр нийгэмд ач тусаа өгч үнэн болох нь батлагдаж байгаа Адам Смитийн эдийн засгийн чөлөөт харилцааны тухай ойлголтоор төлөөлүүлж болно. Учир нь Адам Смитийн үзлээр бол *“Төр ямарваа хязгаарлалт зохицуулалт хийхээс зайлсхийж, харин чөлөөт худалдаа, чөлөөт өрсөлдөөнийг дэмжсэн нөхцлийг бүрдүүлсэн үед аливаа эдийн засаг аяндаа өөрөө хөгжиж, бүгдэд тааламжтай байдлаар өсөн дэвждэг”* байна. Эмх замбараагүй чөлөөт харилцаанаас эдийн засгийн хөгжилд хүргэж буй энэхүү зохицуулах хүчийг Адам Смит “үл үзэгдэх гар” хэмээн нэрлэсэн байдаг. Мөн Францын нэрт сэтгэгч, эдийн засагч Фрэдэрик Бастиа “Эдийн засгийн зохицол” хэмээх номондоо *“хувь хүмүүсийн эрх чөлөө ба ашиг сонирхолуудын чөлөөт харилцаа нь нийгэмд эдийн засгийн зөв голдирол, шударга ёсыг тогтоох жам ёсны үзэгдэл”* гэж томъёолсон нь бий.

Энэ бүхнээс үзэхэд аливаа үзэгдлийн хамгийн төгс зүйл бол хамгийн бага нэгждээ тогтолцоогүй мэт /тогтолцоогүй хаослаг ч гэж дээ угтаа бол яг чин үнэн нь хэнээс ч хараат биш эрх чөлөөтэй байгаа үзэгдэл/ үзэгдэл нь бусадтай эвсэн нийлж, тогтолцоог үүсгэж чадвал хамгийн төгс оршихуй нь байдаг. Яг энэ утгаар монголын уран зохиолын туурвилзүйн арга барил онол хамгийн учир битүүлэг байгаа хэрнээ олон арван гайхамшигтай бүтээлүүдийг бичиж чадсан байгаа нь дотооддоо буюу онолын түвшиндөө тэр хэмжээгээрээ төгс зохицолтой, шилдэг бие даасан онол болох нь харагдаж байна. Үүнээс харахад уран зохиолыг болзолт бүтцэд эрэмблэгдсэн уран сайхны дүрийн тогтолцоо гэж ойлгон, үгээр дүрийг урлаж, дүрээр санааг нээх нь монгол уран зохиолын онолын гол тулгуур үзэл байсан байна.

Мөн Монголын уран зохиол тогтолцоот онолын сэтгэлгээ, бүтэцтэй байсан төдийгүй тэрхүү онол бодрол нь ихээхэн далд хэлбэрт, төгс зохицолд оршиж байжээ

гэдгийг өгүүлэхийн ялдамд орчин үед уран зохиол зэрэг хийсвэр сэтгэлгээний оюуны дээд эрэмбийн зүйлсийн мөн чанарыг олон шинжлэх ухааны нээлт, арга барилын заагт тавьж, чөлөөтэй өргөн дэлгэр хүрээнд судлан шинжлэхгүй бол үнэн арай холуур өнгөрөөд байгааг тэмдэглэе.

SUMMARY

It is very doubtful whether the Mongolian nation has its own theoretical systems for creation style of verses, because there is nothing has considered as a traditional view of theoretical systems of Mongolian verse creation style up to the beginning of the 20th century. Based on this situation, some researchers consider that Mongolians do not have their own theory of verse creation style. And other researchers also view as there is a specific type of theoretical concept for creation style of verses lies within their written works. Order to make sure, after completing research work within a certain frame; we have studied depth in answering question which of these opinions is accurate and found results as follows:

- 1) Achievement of Mongolians for writing masterpieces including small sized popular oral literature to bigger literature for several centuries.
- 2) To equate names of literature types and other related terminologies with its content.
- 3) Seeing the fact of tight harmonized national feature of thinking, general system of philology the verses and written work.

In reality, the above mentioned facts are showing or proving that Mongolians have their own theoretical concept for creation style of verses.

In reality, the above mentioned facts are showing or proving that Mongolians have their own theoretical concept for creation style of verses

- 1) Seeing the fact of tight harmonized national feature of thinking, general system of philology the verses and written work.

In reality, the above mentioned facts are showing or proving that Mongolians have their own theoretical concept for creation style of verses

НОМЗҮЙ

1. Байгалсайхан С. *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Уб., 1995
2. Буяннэмэх С. *Утга зохиолын үүд*. (Гар бичмэл эх) 1936
3. Гаадамба М. *Утга зохиолын онолын товч*. Уб., 1957
4. Гаадамба Ш. *Утга зохиолын онолын үндэс*. Уб., 1989
5. Гаадамба Ш., Цэрэнсодном Д. *Монгол аман зохиолын дээж бичиг*. Уб., 1978
6. Галбаатар Д. *Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь*. Токио., 2002
7. Галбаяр Г. *Уран зохиол шинжлэлийн лекц*. Уб., 2002
8. Герасимович Л. К. *Монгольское стихосложение*. Л., 1975
9. Гүлранса, Данзанванжил, Хишигбат Түүвэр. *Хөх хот*. , 1959
10. Дамдинсүрэн Ц. *Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай өгүүлэл*. “Шинэ толь” сэтгүүл. Уб., 1938. №2 (14)

11. Дамдинсүрэн Ц. *Олег цэцэний орчуулгын тайлбар*. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб. , 1957
12. Дамдинсүрэн Ц. *Монголын уран зохиолын тойм*. Уб. 1957
13. Дулам С. , Хасбаатар Ц. *Утга зохиолын үүд*. Уб. , 1980
14. Ёндон Д. *Төвд, Монголын уран зохиолын харилцааны асуудалд*. Уб. , 1980
15. Жамба Д. *Монгол шүлгийн хэлний тухай өгүүлэл*. Монгол түүх хэл бичиг сэтгүүл. Уб. , 1958. №3
16. Жамбалсүрэн Н. *Монгол шүлэг*. Утга зохиол сонин. №8 1966
17. Жирмунский В. *Теория стиха*. Л. , 1975
18. Инжаннаши В. *Хөх судар*. Тэргүүн дэвтэр. Хөх хот. , 1959
19. Kara G. *Old Mongolian verses without alliteration*. "Ananies USBRE" section linguistic. Budapest. , 1972
20. Квятковский А. *Поэтический словарь*. М. , 1983
21. Лауфер Б. *Очерк монгольской литературы*. Л. , 1927
22. *Монголын нууц товчоо*. Галиглаж хэвлүүлсэн Т. Дашцэдэн. Уб. , 1985
23. Нацагдорж Дашдоржийн *Бүрэн зохиол*. Уб. , 1996
24. Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*. , Bloomington. 1972
25. Отгонсүрэн Д. Д. *Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог*. Уб. , 1984
26. Позднеев А. М. *Образцы народной литературы монгольских племен*. Вып 1. Спб. , 1880
27. Поуха П. "Монголын нууц товчоо"-ны зарим нэгэн шинэ судалгаа. Монгол судлал. Уб. , 1968
28. *Хэл зохиол судлал*. Х боть. Уб. , 1975
29. Ринчен Б. *Монгол шүлгийн учир*. "Хэл зохиол" цуврал бичиг. Уб. , 1969
30. Руднеев А. *Образцы монгольской народной словесности*. Спб. , 1880
31. Содном Б. Д. *Нацагдоржийн уран зохиолын тухай*. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. IV дэвтэр. Уб. , 1962
32. Содном Балданы *Монгол шүлгийн арга маяг*. Зохиол судлал. Уб. , 2008-2009
33. Туденов Г. *Бурятской стихосложение*. Улан Уде. , 1958
34. Түдэв Лодонгийн *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган VI. Уб. , 2002
35. *Утга зохиол судлалын унших бичиг*. Уб. , 1995
36. Kesigtoytaqu С. *Mongyol-un erten-ь udq-a jokiyal-un sin-e sudulul. Öbür mongyol-un arad-un keblel-ын qoriy-a.* , 1999
37. Хүрэлбаатар Л. *Сонгодог уламжлал, монгол яруу найраг*. Уб. , 1989
38. Хүрэлбаатар Л. *Эсэруагийн эгшиг дуун*. Уб. , 1999
39. Цэдэв Д. *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. Уб. , 1974
40. Цэнд Д. *Монголын орчин үеийн уянгын яруу найраг*. Уб. , 1972
41. Цэнд Д. *Монгол шүлгийн тогтолцооны асуудалд*. "Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд" Уб. , 1979
42. Цэрэнсодном Д. *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*. Уб. , 1977
43. Чимид Ч. *Монгол шүлгийн тогтолцоо*. "Үгийн ил шид" эмхэтгэл. Уб. , 1968
44. *Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal-i tobčilan quriyaysan altan tobči kemekü orusibai*. Orusil bičigsen Ša. Bira,. Ulaγanbayatur. , 1990
45. Явуухулан Бэгзийн *Түүвэр зохиол*. Уб. , 1985